



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

584.	Зарим хүмүүсийг шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай	Дугаар 150	2246
585.	Засгийн газарт чиглэл өгөх тухай	Дугаар 151	2246
586.	Албан тушаалаас чөлөөлөх тухай	Дугаар 152	2248
587.	Алтай ханы Таванбогд уул болон Говь гурван сайхан уулын Их Тахилгат хайрханыг төрийн тахилгатай болгох тухай	Дугаар 153	2248
588.	Зарим хүмүүсийг шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалд томилох тухай	Дугаар 165	2249
589.	Зарим хүмүүсийг шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай	Дугаар 166	2250

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

590.	Төрийн ёслол хүндэтгэлийн өргөө цогцолборыг нээлттэй болгох тухай	Дугаар 3	2250
591.	Журамд нэмэлт оруулах тухай	Дугаар 4	2254
592.	Төрийн албаны интернэтийн зохистой хэрэглээг бий болгох тухай	Дугаар 5	2256
593.	Засгийн газрын агентлагийн талаар авах зарим арга хэмжээний тухай	Дугаар 6	2257
594.	Комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай	Дугаар 7	2262
595.	Улаанбаатар хотод ажил эхлэх цагийг тогтоох тухай	Дугаар 8	2263



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2012 оны 08 дугаар
сарын 14-ний өдөр

Дугаар 150

Улаанбаатар
хот

Зарим хүмүүсийг шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Шүүхийн тухай Монгол Улсын хуулийн 32 дугаар зүйлийн 32.4, 58 дугаар зүйлийн 58.1.3, 58.1.4 дэх заалтыг тус тус баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Биеийн эрүүл мэндийн байдлаар үүрэгт ажлаа гүйцэтгэх боломжгүй болсон Даваажавын Батсайханыг Улсын дээд шүүхийн шүүгчийн, тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн Загдын Цэнгэнбаяр, Очирбатын Гэрэл нарыг Нийслэлийн шүүхийн шүүгчийн, Мижидийн Цэрэнбалжирыг нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн шүүхийн шүүгчийн, Силамын Сайраныг Баян-Өлгий аймгийн Захиргааны хэргийн шүүхийн шүүгчийн, бүрэн эрхийн хугацаа дууссан Адилбишийн Сайнтөгсийг Дорноговь аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2012 оны 08 дугаар
сарын 16-ны өдөр

Дугаар 151

Улаанбаатар
хот

Засгийн газарт чиглэл өгөх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн, Монгол Улс Лондон-2012 Зуны олимпын 30 дугаар наадамд хамгийн олон медаль хүртсэн түүхэн амжилтыг бахархан тэмдэглэж, биеийн тамир, спортыг хөгжүүлэхэд гарамгай гавьяа байгуулж, ирээдүй хойч хүүхэд залуучуудад үлгэр дууриалал үзүүлж, эх орныхоо нэр алдрыг дэлхий дахинд дуурсгаж, олимпын наадам, олимпын спортын төрлөөр Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс медаль хүртсэн, үндэсний бахархал болсон үе үеийн тамирчдын нэр их хөдөлмөр, хичээл зүтгэлийг үнэлж, тогтмол урамшуулал олгож, амьдралын баталгааг нь хангах зорилгоор ЗАРЛИГ БОЛГОХ нь:



Нэг. Үе үеийн Олимпийн наадам /Зуны олимп, өвлийн олимп, пара олимп/, Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс олимпийн спортын зай, жинд медаль хүртсэн Монгол Улсын иргэнд насан туршид нь сар бүр урамшуулал олгох дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт чиглэл болгосугай.

Хоёр. Тамирчдад сар бүр олгох урамшууллын хэмжээг дараах байдлаар тогтоосугай. Үүнд:

1. Олимпийн наадмаас алтан медаль хүртсэн тамирчинд 4 сая төгрөгийн;

2. Олимпийн наадмаас мөнгөн медаль хүртсэн тамирчинд 3 сая төгрөгийн;

3. Олимпийн наадмаас хүрэл медаль хүртсэн тамирчинд 2 сая төгрөгийн;

4. Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс олимпийн спортын зай, жинд алтан медаль хүртсэн тамирчинд 2 сая төгрөгийн;

5. Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс олимпийн спортын зай, жинд мөнгөн медаль хүртсэн тамирчинд 1 сая төгрөгийн;

6. Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс олимпийн спортын зай, жинд хүрэл медаль хүртсэн тамирчинд 500 мянган төгрөгийн.

Гурав. Урамшуулалд олгох мөнгийг жил бүрийн улсын төсөвт тусгах бөгөөд урамшуулал олгоход тавигдах баримт бичгийн шаардлага, олгох журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран баталж хэрэгжүүлэх, шаардлагатай бол урамшууллын хэмжээг төгрөгийн ханштай уялдуулан шинэчлэн тогтоож байх.

1. Урамшууллыг зөвхөн тухайн медаль хүртсэн тамирчинд сар бүр олгох.

2. Тухайн тамирчны гаргасан амжилтын урамшууллыг дараа оны 01 дүгээр сарын 01-нээс эхлэн олгож байх.

3. Олимпийн наадам, Дэлхийн аварга шалгаруулах тэмцээний медальтай, нас барсан тамирчны эхнэр, нөхөр, хүүхэд хүсэлт гаргавал 1 жилд олгогдох урамшуулалтай тэнцэх хэмжээний буцалтгүй тусламжийг нэг удаа олгох.



Дөрөв. Урамшуулал олгох ажлыг 2013 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхлэхийг Засгийн газар /Н.Алтанхуяг/-т чиглэл болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Ц.ЭЛБЭГДОРЖ

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Н.АЛТАНХУЯГ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2012 оны 08 дугаар
сарын 23-ны өдөр

Дугаар 152

Улаанбаатар
хот

Албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Төрийн өөр ажил, албан тушаалд томилогдсонтой холбогдуулан Монгол Улсаас Бүгд Найрамдах Солонгос Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Д.Гэрэлийг 2012 оны 4 дүгээр сарын 18-ны өдрөөр тасалбар болгон үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2012 оны 08 дугаар
сарын 23-ны өдөр

Дугаар 153

Улаанбаатар
хот

Алтай ханы Таванбогд уул болон Говь гурван сайхан уулын Их Тахилгат хайрханыг төрийн тахилгатай болгох тухай

Баян-Өлгий болон Өмнөговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэр, хүсэлтийг дэмжиж Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх заалт, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг тус тус баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ нь:



1. Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын нутаг дэвсгэрт орших Алтай ханы Таванбогд уул, Өмнөговь аймгийн Хүрмэн суманд орших Говь гурван сайхан уулын Их Тахилгат хайрханыг тус тус төрийн тахилгатай болгосугай.

2. Төрийн тахилгатай уул овооны тэнгэрийг тайх төрийн ёслолыг цаашид 5 жилд нэг удаа үйлдэж байхаар тогтоосугай.

3. Энэхүү зарлиг гарсантай холбогдуулан “Төрийн тахилгатай уул овооны тэнгэрийг тайх тахилгын ёслолын журам”-ын 1.2, 1.5 дугаар заалтад нэмэлт, өөрчлөлт оруулахыг Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга /П.Цагаан/-д үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2012 оны 09 дүгээр
сарын 07-ны өдөр

Дугаар 165

Улаанбаатар
хот

Зарим хүмүүсийг шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалд томилох тухай

Шүүхийн тухай Монгол Улсын хуулийн 32 дугаар зүйлийн 32.1, 32.4 дэх хэсэгт заасныг баримтлан Шүүхийн Ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Эрдэнэ-Очирын Болормааг Дорноговь аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн Ерөнхий шүүгчийн, Хаянхярваагийн Оюунжаргалыг Өвөрхангай аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн, Лхамсүрэнгийн Алтанг Увс аймаг дахь сум дундын шүүхийн Ерөнхий шүүгчийн, Баттулгын Бадрахгэрэлийг Ховд аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн Ерөнхий шүүгчийн, Нанзадын Дамдинсүрэнг Говьсүмбэр аймгийн Захиргааны хэргийн шүүхийн шүүгчийн, Баатаржавын Ихтамирыг Завхан аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн шүүгчийн, Мөнхбаярын Нямбаярыг Ховд аймгийн шүүхийн шүүгчийн, Мягмарын Энхмандахыг Хэнтий аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Ц.ЭЛБЭГДОРЖ



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2012 оны 09 дүгээр
сарын 07-ны өдөр

Дугаар 166

Улаанбаатар
хот

Зарим хүмүүсийг шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Шүүхийн тухай Монгол Улсын хуулийн 58 дугаар зүйлийн 58.1.2 дахь хэсэгт заасныг баримтлан Шүүхийн Ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Төрийн өөр ажил, албан тушаалд томилогдсон Хаянхярваагийн Оюунжаргалыг Хэнтий аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчийн, Мөнхбаярын Нямбаярыг Ховд аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 8 дугаар
сарын 25-ны өдөр

Дугаар 3

Улаанбаатар
хот

Төрийн ёслол хүндэтгэлийн өргөө цогцолборыг нээлттэй болгох тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Төрийн ёслол хүндэтгэлийн өргөө цогцолбор, Монгол төрийн түүхийн музейг 2012 оны 8 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн олон нийтэд нээж, байнгын үйл ажиллагаатай болгосугай.

2. Монгол төрийн түүхийн музейг иргэд үзэж танилцах маршрутыг хавсралт ёсоор баталсугай.

3. Музейн дээврийн хучилтыг засварлахад 294.038.558 (хоёр зуун ерэн дөрвөн сая гучин найман мянга таван зуун тавин найман) төгрөг, хяналтын камер болон дууны техник хэрэгсэл худалдан авахад 129.781.555 (нэг зуун хорин есөн сая долоон зуун наян нэгэн мянга таван зуун тавин таван) төгрөг, Чингис хааны дурсгалын хөшөө, галерейн гэрэлтүүлгийг шинэчлэхэд 44.322.317 (дөчин дөрвөн сая гурван зуун хорин хоёр мянга гурван зуун арван долоон) төгрөг, нийт 468.142.430 (дөрвөн зуун жаран



найман сая нэг зуун дөчин хоёр мянга дөрвөн зуун гучин) төгрөгийг 2012 оны төсвийн тодотголд тусган шийдвэрлэхийг Сангийн сайд Ч.Улаан, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Сайханбилэг нарт даалгасгай.

4. Төрийн ёслол хүндэтгэлийн өргөө цогцолбор, Монгол төрийн түүхийн музейг олон нийтэд нээлттэй болгож байгаатай холбогдуулан гарах бусад зардлыг 2013 оны улсын төсөвт тусган санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Ч.Улаан, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Сайханбилэг нарт даалгасгай.

5. Цаашид Төрийн ёслол хүндэтгэлийн өргөө цогцолборт олон улсын болон монголын уран бүтээлчдийн үзэсгэлэн зохион байгуулж байх талаар холбогдох арга хэмжээ авахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Сайханбилэгт үүрэг болгосугай.

6. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Төрийн ордны хамгаалалт, үйлчилгээний журам”-д холбогдох байгууллагуудтай зөвшилцөн зохих нэмэлт, өөрчлөлт оруулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Сайханбилэгт даалгасгай.

7. “Монгол төрийн түүхийн музей байгуулах тухай” Засгийн газрын 2009 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн 30 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн “...Монголын Үндэсний музейн харьяанд” гэснийг “Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын харьяанд” гэж өөрчилж, мөн зүйлийн “...Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ё.Отгонбаярт” гэснийг, тогтоолын 2 дугаар зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

8. Монгол төрийн түүхийн музейн үйл ажиллагааг мэргэжил арга зүйн удирдлагаар ханган, музейн сан хөмрөгийн хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг Соёл, спорт, аялал жуулчлалын сайд Ц.Оюунгэрэлд даалгасгай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Н.АЛТАНХУЯГ

САНГИЙН САЙД

Ч.УЛААН

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**


Ч.САЙХАНБИЛЭГ



Засгийн газрын 2012 оны 3 дугаар
тогтоолын хавсралт

ТӨРИЙН ОРДНЫ ЁСЛОЛ ХҮНДЭТГЭЛИЙН ЦОГЦОЛБОРТОЙ ТАНИЛЦАХ МАРШРУТ

2 ДУГААР ДАВХАР



* Төрийн ордны өмнөх Чингис хааны хөшөөний баруун хаалгаар орж өлгүүрийн хажуугийн шатаар доош бууж Монгол төрийн түүхийн музей рүү орно.


1 ДҮГЭЭР ДАВХАР



* Монгол төрийн түүхийн музейтэй танилцаад зүүн шатаар өгсөж Баганат танхим буюу Төрийн ёслол хүндэтгэлийн цогцолбор руу орно.




2 ДУГААР ДАВХАР



* Төрийн ёслол хүндэтгэлийн цогцолбортой танилцаад баруун шатаар өгсөж Төрийн есөн хөлт цагаан туг байрлах танхим руу орно.

3 ДУГААР ДАВХАР



* Төрийн есөн хөлт цагаан туганд хүндэтгэл үзүүлсний дараа зүүн талд байрлах шатаар 2 дугаар давхар руу бууж төрийн ордны өмнөх Чингис хааны хөшөөний зүүн талын хаалгаар гарна.



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 8 дугаар
сарын 25-ны өдөр

Дугаар 4

Улаанбаатар
хот

Журамд нэмэлт оруулах тухай

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 6.1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Засгийн газрын 2008 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн 109 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн ёслолын журам”-д дор дурдсан агуулга бүхий 19¹, 19² дугаар зүйлийг тус тус нэмсүгэй:

“19¹. Их эзэн Чингис хааны хөшөөнд Хүндэт харуул хүндэтгэл үзүүлэх ёслол:

19^{1.1}. Их эзэн Чингис хааны хөшөөнд Хүндэт харуул хүндэтгэл үзүүлэх ёслолын ажиллагааг долоо хоног бүрийн Бямба, Ням гарагийн Морин цаг /11.40/-т зохион байгуулна.

19^{1.2}. Ёслолын ажиллагаа эхлэхээс өмнө Хүндэт харуулын 26 цэрэг Төрийн ордны урд талын баруун, зүүн жигүүрт хуваагдан жагсаж бэлэн болсон байна.

19^{1.3}. Төрийн ордны урд талбайд 11.40 цагт “Марш” аялгуу эгшиглэнэ.

19^{1.4}. Төрийн ордны урд талын баруун, зүүн жигүүрт байрлах Хүндэт харуулын цэрэг алхаж, Их эзэн Чингис хааны хөшөөний хоёр талаар жагсаалын алхаагаар өгсөн талбай, шат болон хөшөөний дэргэд дэлгэмэл байдлаар 7 минутын дотор байраа эзэлнэ.

19^{1.5}. Хүндэт харуулын цэрэг хөшөөний дэргэд 13 минут зогсох бөгөөд 12.00 цагт жагсаалын даргын командаар ёслолын алхаагаар буцаж бууна.

19^{1.6}. Ёслолын ажиллагааны үеэр иргэд дурсгалын гэрэл зураг авахуулж болно.



19². Төрийн далбааг мандуулах, буулгах ёслол:

19².1. Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд заасан нийтээр тэмдэглэх баярын өдрүүдэд Их жанжин Д.Сүхбаатарын талбайд Төрийн далбаа мандуулах ёслолын ажиллагааг зохион байгуулна.

19².2. Хүндэт харуулын 18 цэрэг 08.55 цагт Төрийн ордны урд талын баруун, зүүн жигүүрээс жагсаалын алхаагаар алхаж Д.Сүхбаатарын хөшөөний хойно байрлах Төрийн далбааны суурийн дэргэд ирж зогсоно. Энэ үед “Марш” аялгуу эгшиглэнэ.

19².3. “Туг хүндэтгэх аялгуу” 9.00 цагт эгшиглэхэд баруун гар талд байрлах Хүндэт харуулын цэрэг далбаа баригчийн гар дээрээс Төрийн далбааг авч эвхээсийг задална. Далбаа баригч бүчүүдийг оосорт бэхлэн уяж, Төрийн далбааг мандуулахад бэлэн болгоно. Энэ үед далбаа баригчийн зүүн гар талд байрлах Хүндэт харуулын цэрэг гэдрэг нэг алхаж зогсоно.

19².4. Төрийн дуулал эгшиглэмэгц далбаа баригч Төрийн далбааг мандуулна. Төрийн дууллын 1 дүгээр бадгийн 3 дахь мөр эхэлмэгц далбаа баригчийн баруун гар талд байрлах Хүндэт харуулын цэрэг далбааг нэгэн зэрэг намируулан гэдрэг нэг алхаж далбааны зүг хараа гарган ёслоно.

19².5. Төрийн дууллын 2 дугаар бадгийн 2 дахь мөр дуусмагц далбаа баригч далбааг гүйцэд мандуулан гэдрэг нэг алхалж далбааны зүг хараа гарган ёслоно.

19².6. Далбааг мандуулж дууссаны дараа Хүндэт харуулын цэрэг Төрийн ордны урд талын баруун, зүүн талын жигүүр рүү жагсаалын алхаагаар буцна.

19².7. Нийтээр тэмдэглэх баярын өдрийн (дараалсан өдрүүд байх тохиолдолд сүүлийн өдрийн) 18.00 цагт Хүндэт харуулын цэрэг Төрийн ордны урд талын баруун, зүүн жигүүрээс жагсаалын алхаагаар алхаж Д.Сүхбаатарын хөшөөний хойно байрлах Төрийн далбааны суурийн дэргэд ирж зогсоно.



19².8. Төрийн дуулал эгшиглэмэгц Төрийн далбааг далбаа баригч буулгана. Төрийн далбааг буулгамагц Хүндэт харуулын цэрэг далбааны үзүүр хэсгийн хоёр булангаас хоёр гараагаа барихад далбаа баригч бүчүүдийг тайлна. Энэ үед далбаа баригч үзүүрийн хэсгийн улаан, цэнхэр хэсгийн заагийн хоёр талаас барьж өгөхөд үзүүрийн хэсгээс барьж буй Хүндэт харуулын цэрэг далбааны улаан хэсгийг дээш нугалан цэнхэр хэсэгтэй давхцуулан барьж буцаан доош нугалан соёмботой хэсгийг дээш харуулан барихад Хүндэт харуулын цэрэг соёмбо үсгийн хоёр талыг доош хагас нугалан давхарлаж эвхээд далбаа баригчийн хоёр гар дээр тавина. Энэ үед далбаа баригч тус тусын байранд очиж зогсоно.

19².9. Хүндэт харуулын цэрэг ёслолын алхаагаар Төрийн ордны баруун, зүүн талаар алхаж байрандаа буцна.”

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Н.АЛТАНХУЯГ

**БАТЛАН ХАМГААЛАХЫН
САЙД**

Д.БАТ-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 8 дугаар
сарын 25-ны өдөр

Дугаар 5

Улаанбаатар
хот

Төрийн албаны интернэтийн зохистой хэрэглээг бий болгох тухай

Төрийн албан хаагчдын хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, төрийн байгууллага хооронд мэдээлэл солилцох боломж бүрдүүлэх, төрийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах, төрийн албаны интернэтийн зохистой хэрэглээг бий болгох зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Төрийн албан хаагчдын албан хэрэгцээнд ашиглагдаж байгаа компьютерийг интернэтээс тусгаарлах, тухайн компьютерээс мэдээлэл хуулах, мэдээлэл гадагш гаргах аливаа эх үүсвэр, оролтыг хаах, шаардлагатай мэдээллийг зөвхөн албаны электрон шуудангийн хаягаар хүлээн авах техникийн боломжийг бүрдүүлж, төрийн байгууллагуудад



үүсгэсэн утасгүй интернэтийн бүсийг Төрийн ордноос бусад газарт хааж, тодорхой зөвшөөрөгдсөн газарт ашиглах нөхцөл бүрдүүлэн шаардлагатай дүрэм, журмыг боловсруулж мөрдүүлэхийг Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газар, Тагнуулын ерөнхий газарт даалгасугай.

2. Төрийн албан хаагчид албан ажлынхаа хүрээнд интернэт ашиглах боломж бүхий орчин бүрдүүлэх талаар холбогдох арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газарт шаардагдах санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэхийг Сангийн сайд Ч.Улаан нарт тус тус даалгасугай.

3. Төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээ, Төрийн ордны мэдээллийн сүлжээ, дэд бүтэц байгуулах ажлыг уялдуулан зохион байгуулахыг Тагнуулын ерөнхий газрын дарга Д.Гэрэлд, төрийн мэдээллийн сүлжээ байгуулахад дэмжлэг үзүүлж, шаардлагатай техникийн нөхцөл гаргах ажлыг зохион байгуулахыг Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газарт, шаардагдах хөрөнгийг шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллахыг Сангийн сайд Ч.Улаанд тус тус даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Н.АЛТАНХУЯГ

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

Ч.САЙХАНБИЛЭГ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 8 дугаар
сарын 27-ны өдөр

Дугаар 6

Улаанбаатар
хот

Засгийн газрын агентлагийн талаар авах зарим арга хэмжээний тухай

Засгийн газрын тухай хуулийн 18³ дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 5.1, 6.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Улсын Их Хурлын 2012 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-



ийн дагуу Засгийн газрын тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлагуудыг хавсралт ёсоор зохион байгуулан ажиллуулсугай.

2. Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг шинээр болон өөрчлөн байгуулагдсантай холбогдуулан Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо, Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газар, Хүүхдийн төлөө газар, Төр, засгийн үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газар, Удирдлагын академи, Дипломат байгууллагын үйлчилгээ, аж ахуйн газар, Гадаадын хөрөнгө оруулалтын газар, Ойн газар, Усны газар, Соёл, урлагийн хороо, Мэргэжлийн боловсрол, сургалтын газар, Төмөр замын газар, Авто тээврийн газар, Авто замын газар, Газрын харилцаа, барилга, геодези, зураг зүйн газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Жижиг, дунд үйлдвэрийн газар, Эрчим хүчний газар, Биеийн тамир, спортын газар, Эрүүл мэндийн газрыг тус тус татан буулгасугай.

3. Татан буугдаж байгаа Засгийн газрын агентлагийн албан хаагчдыг орон тоо, цалингийн сангийн хамт тухайн асуудлыг хариуцсан яамны мэдэлд шилжүүлсүгэй.

4. Дор дурдсан арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүдэд даалгасугай:

4.1. яамны мэдэлд шилжин ирсэн албан хаагчдыг мэргэжил, мэргэшлийн дагуу байршуулах;

4.2. эрхлэх асуудлынхаа хүрээнд үйл ажиллагаа явуулах Засгийн газрын агентлагийн орон тооны дээд хязгаар болон үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн талаар санал боловсруулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлэх;

4.3. яам, Засгийн газрын агентлагийн хэрэгжүүлж байсан зарим чиг үүргийг улсын үйлдвэрийн газар, мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагад шилжүүлэх талаар санал боловсруулан Ерөнхий сайдад танилцуулсны үндсэн дээр Засгийн газарт оруулах.

5. Дор дурдсан арга хэмжээ авахыг Засгийн газрын холбогдох гишүүд, Төрийн өмчийн хороо (Ц.Нанзаддорж)-нд даалгасугай:

5.1. Засгийн газрын агентлагуудыг татан буулгах ажлыг зохион байгуулах комиссыг холбогдох хууль тогтоомжийн дагуу томилон ажиллуулах;



5.2. татанбуугдсан Засгийн газрын агентлагуудынашиглаж байсан мэдээ, баримт бичиг, төрийн өмчийн хадгалалт, хамгаалалтыг хариуцан, холбогдох яам, эрх бүхий байгууллагад шилжүүлэх, үндсэн болон эргэлтийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх, хаалтын тайлан тэнцэл гаргах;

5.3. нийгмийн даатгалын болон татварын байгууллагатай тооцоо хийж дуусгах.

6. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг байгуулах тухай” Засгийн газрын 2008 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 64 дүгээр тогтоолын 4 дүгээр зүйлээс бусад зүйл, заалт, “Агентлаг байгуулах тухай” Засгийн газрын 2009 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн 257 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Н.АЛТАНХУЯГ

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

Ч.САЙХАНБИЛЭГ

Засгийн газрын 2012 оны 6 дугаар
тогтоолын хавсралт

**ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ
БОЛОН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГИЙН
ЖАГСААЛТ**

Эрхлэх асуудлын хүрээ, харьяалал	Засгийн газрын тохируулагч агентлаг	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг
Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд	1. Тагнуулын ерөнхий газар 2. Цөмийн энергийн газар 3. Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газар	



<p>Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд</p>	<p>4.Мэргэжлийн хяналтын ерөнхий газар 5.Онцгой байдлын ерөнхий газар 6.Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар 7.Стандартчилал, хэмжил зүйн газар</p>	<p>1.Худалдан авах ажиллагааны газар 2.Оюуны өмчийн газар</p>
<p>Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд</p>		<p>3.Цаг уур, орчны шинжилгээний газар</p>
<p>Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд</p>		<p>4.Гаалийн ерөнхий газар 5.Татварын ерөнхий газар</p>
<p>Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээнд</p>	<p>8.Цагдаагийн ерөнхий газар 9.Хил хамгаалах ерөнхий газар</p>	<p>6.Улсын бүртгэлийн ерөнхий газар 7.Архивын ерөнхий газар 8.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар 9.Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газар</p>
<p>Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээнд</p>		<p>10.Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар</p>



Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын хүрээнд	10.Зэвсэгт хүчний жанжин штаб	
Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд		11.Иргэний нисэхийн ерөнхий газар
Уул уурхайн сайдын эрхлэх асуудлын хүрээнд		12.Ашигт малтмалын газар 13.Газрын тосны газар
Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын эрхлэх асуудлын хүрээнд	11.Төрийн өмчийн хороо	14.Мал эмнэлэг, үржлийн газар
Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээнд		15.Нийгмийн даатгалын ерөнхий газар 16.Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газар 17.Хүүхдийн төлөө үндэсний газар



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 8 дугаар
сарын 27-ны өдөр

Дугаар 7

Улаанбаатар
хот

Комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Эзэн богд Чингис хаан-Тэмүүжиний мэндэлсний 850 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Ой тэмдэглэх тухай” Засгийн газрын 2012 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн 196 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Н.АЛТАНХУЯГ

ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД

Л.БОЛД

**СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН САЙД**

Ц.ОЮУНГЭРЭЛ

Засгийн газрын 2012 оны 7 дугаар
тогтоолын хавсралт

ЭЗЭН БОГД ЧИНГИС ХААН-ТЭМҮҮЖИНИЙ МЭНДЭЛСНИЙ 850 ЖИЛИЙН ОЙН АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга -Монгол Улсын Ерөнхий сайд

Дэд дарга -Монгол Улсын сайд, Засгийн газрын
Хэрэг эрхлэх газрын дарга

Гишүүд: -Гадаад харилцааны сайд;
-Сангийн сайд;



- Батлан хамгаалахын сайд;
- Боловсрол, шинжлэх ухааны сайд;
- Соёл, спорт, аялал жуулчлалын сайд;
- Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга (тохиролцсоноор);
- Ерөнхийлөгчийн Олон нийтийн харилцаа, нийтлэг бодлогын зөвлөх (тохиролцсоноор);
- Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга;
- Хэнтий аймгийн Засаг дарга;
- Шинжлэх ухааны академийн ерөнхийлөгч;
- Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн ерөнхий захирал;
- Төрийн ёслолын албаны дарга.
- Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга.

**Нарийн бичгийн
дарга**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 8 дугаар
сарын 27-ны өдөр

Дугаар 8

Улаанбаатар
хот

Улаанбаатар хотод ажил эхлэх цагийг тогтоох тухай

Засгийн газрын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2, 30 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн авто замын ачааллыг зохицуулах зорилгоор нийслэлд байршин, үйл ажиллагаа явуулдаг яам, төрийн захиргааны



байгууллага болон тэдгээрийн харьяа байгууллага, бусад төрийн болон төсөвт байгууллагуудын ажил эхлэх цагийг 08.00 цаг, ажил дуусах цагийг 17.00 цаг; ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаа эхлэх цагийг 08.00 цаг; их, дээд сургуулийн хичээл эхлэх цагийг 09.00 цаг байхаар тогтоож 2012 оны 9 дүгээр сарын 3-ны өдрөөс эхлэн мөрдсүгэй.

2. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.1.6, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасныг үндэслэн нийслэлд үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагуудын ажлын цагийн хуваарьт холбогдох зохицуулалт хийхийг Нийслэлийн Засаг дарга Э.Бат-Үүлд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Н.АЛТАНХУЯГ

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

Ч.САЙХАНБИЛЭГ

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.
Улаанбаатар-12, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeel@parliament.mn
Утас: 262420, 329612
Хэвлэлийн хуудас: 1.25
Индекс: 14003